



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Г Нийтлэг шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.5 дахь заалтад заасан давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшигийн улмаас хохирол барагдуулах үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлагыг нэгдүгээр, тусгай шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газар (хошууч генерал Г.Ариунбуян)-т даалгасугай.

3.Энэ тушаалыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН



0325100183

Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 18.. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖ АХҮЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ БУСАД ГАМШГИЙН УЛМААС ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Нэг. Зорилго, хамрах хүрээ

1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.5-д заасан давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшигийн улмаас хохирол барагдуулах чиглэлээр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийсэн, санхүүгийн дэмжлэг, хандив олгосон татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагад татварын хөнгөлөлт эдлэх үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлоход энэхүү шаардлагын зорилго оршино.

1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд заасан давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшигийн улмаас хохирол барагдуулах чиглэлээр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийсэн, санхүүгийн дэмжлэг, хандив олгосон татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагад энэхүү шаардлага хамаарна.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

2.1. Энэхүү шаардлагад хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшиг” гэдэгт Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 болон 4.1.3-т заасан аюулт үзэгдэл, осол нь Засгийн газрын 2018 оны 327 дугаар тогтоолоор баталсан “Гамшигийг тодорхойлох шалгуур үзүүлэлт” дэх аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлыг хангасан тохиолдлыг;

2.1.2. “Давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшигийн улмаас хохирол барагдуулах үйл ажиллагаа” гэдэгт энэхүү шаардлагын 2.1.1 дэх хэсэгт заасан тохиолдлын улмаас учирсан хохирлыг барагдуулах хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, санхүүгийн дэмжлэг болон бараа, материалын хандивыг;

2.1.3. “Хөрөнгө оруулалт” гэдэгт энэхүү шаардлагын 2.1.1 дэх хэсэгт заасан тохиолдлын улмаас учирсан хохирлыг барагдуулах зорилгын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг;

2.1.4.“Бүтээн байгуулалт” гэдэгт энэхүү шаардлагын 2.1.1 дэх хэсэгт заасан тохиолдлын улмаас учирсан хохирлыг барагдуулах зорилгын хүрээнд барьсан барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн байгууламжийг;

2.1.5.“Санхүүгийн дэмжлэг, хандив” гэдэгт энэхүү шаардлагын 2.1.1 дэх хэсэгт заасан тохиолдлын улмаас учирсан хохирлыг барагдуулах зорилгын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд сайн дурын үндсэн дээр үзүүлсэн мөнгөн болон биет хөрөнгийг.

Гурав. Татварын хөнгөлөлт эдлэх давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшгийн улмаас хохирол барагдуулах үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага

3.1.Хохирол барагдуулах хөрөнгө оруулалт нь дараах шаардлагыг хангасан байна:

3.1.1.Татвар төлөгчийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт өөр хуулийн этгээдийн элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан бодитой хөрөнгө оруулалт байх;

3.1.2.Татвар төлөгчийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.1, 8.5-д заасан үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй байх;

3.1.3.Татвар төлөгч бусад этгээдэд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд тухайн этгээдтэй төсөл, үйл ажиллагаанд нь хөрөнгө оруулалт хийх гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлж, хөрөнгө оруулалт авч буй талын санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх.

3.2.Хохирол барагдуулах бүтээн байгуулалт нь дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1.Аюулт үзэгдэл, ослын улмаас учирсан хохирол барагдуулах, сэргээн босгох зорилготой байх;

3.2.2.Холбогдох стандарт, норм ба дүрмийг хангасан байх;

3.2.3.Татвар төлөгчийн өөрийн хэрэгжүүлэх бүтээн байгуулалт, төслийн хувьд тухайн татвар төлөгчийн удирдах дээд байгууллагын баталсан бизнесийн төлөвлөгөөнд туссан, санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх;

3.2.4.Нийгмийн хариуцлагын хүрээнд нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд хэрэгжих бүтээн байгуулалтыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.13-т заасан маягтын дагуу бүртгүүлсэн байна.

3.3.Хохирол барагдуулах санхүүгийн дэмжлэг, хандив нь дараах шаардлагыг хангасан байна:

3.3.1.Хариу төлбөргүй шилжүүлсэн мөнгөн болон биет хөрөнгө байх;

3.3.2.Санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авч буй тал нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хандив олгох татвар төлөгчтэй ашиг сонирхлын зөрчилгүй, хамааралгүй байх;

3.3.3.Иргэний хуульд заасныг баримтлан санхүүгийн дэмжлэг, хандивын зориулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д нийцүүлэн тусгасан гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлсэн байх;

3.3.4.Энэхүү шаардлагын 3.3.3-т заасны дагуу байгуулсан гэрээг тухай бүр харьяа татварын алба болон Онцгой байдлын байгууллагад бүртгүүлсэн байх;

3.3.5.Санхүүгийн дэмжлэг, хандив олгосон болон хүлээн авсан тал нь тухайн санхүүгийн дэмжлэг, хандивыг энэхүү шаардлагын 3.3.3-т заасан гэрээнд тусгасан зориулалтын дагуу тухайн тайлант хугацаанд зарцуулсан гэдгийг хүлээн зөвшөөрч, гэрээг цуцлах болон татгалзахгүй тухайгаа илэрхийлсэн акт үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байх;

3.3.6.Санхүүгийн дэмжлэг, хандивын зардал нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх.

3.4.Энэхүү шаардлагын 3.1, 3.2, 3.3-т заасан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан хасагдах зардлын шаардлагыг хангасан байна.

3.5.Энэхүү шаардлагын 2.1.1 дэх хэсэгт заасан давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшиг болсон тохиолдол нь улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын тодорхойлолт эсхүл гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн акт, дүгнэлтээр баталгаажсан байна.

3.6.Давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшгийн улмаас хохирол барагдуулах хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь харьяа онцгой комисс болон Онцгой байдлын байгууллагад бүртгэгдсэн байна.

Дөрөв. Хяналт, баталгаажуулалт

4.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.5-д заасан хөнгөлөлт эдлэх үйл ажиллагаа нь түүнд тавигдах шаардлагыг хангасан эсэхэд бүх шатны Онцгой байдлын байгууллага хяналт тавина.

4.2.Онцгой байдлын байгууллага нь энэхүү шаардлагын 2.1.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг бүртгэж, мэдээллийн сан үүсгэнэ.

4.3. Албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан үйл ажиллагааны талаарх статистик мэдээллийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын статистикийн асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгж хагас жил тутам нэгтгэн гаргана.

4.4. Нийслэл, орон нутгийн Онцгой байдлын газар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.5-д заасан үйл ажиллагааг бүртгэн авч, мэдээллийг улирал тутам Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санхүү, ар тал, хангалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын нэгжид ирүүлнэ.

4.5. Татварын алба албан татварын хөнгөлөлтөд хамрагдахаар ирүүлсэн татвар төлөгчийн тайлант үеийн татварын хөнгөлөлтийн мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.6. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санхүү, ар тал, хангалт хариуцсан нэгж болон улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн асуудал хариуцсан нэгж ирүүлсэн мэдээллийг 30 хоногийн дотор хянаж, баталгаажуулан татварын асуудал эрхэлсэн байгууллагад хүргүүлнэ.

Тав. Бусад

5.1. Аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийг татвараас зайлсхийх үндсэн зорилгоор ашигласан тохиолдолд татварын холбогдох хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

5.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулагдаагүй, гэрээний хэрэгжилт хангагдаагүй болох нь тогтоогдсон тохиолдолд татварын холбогдох хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

---оОо---

ДАВАГДАШГҮЙХЧИН ЗҮЙЛ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ БУСАД ГАМШГИЙН УЛМАС ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Монгол Улсын Шадар сай^{дын}
 2025 оны дугаар сарын 15.-ны
 едрийн 40 дугаар хоёрдугаар
 хавсралт

№	Төрөл, хэлбэр	Чиглэл, зориулалт	Холбогдох эрх зүйн акт, стандарт	Тусгай шаардлага	Тайлбар
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.5. давагдашгүй хүчин зүйл болон түнгэй адилтгах бусад гамшигийн улмаас хохирол барагдуулах					
1.	Хөрөнгө оруулалт	-хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, -дэд бүтцийг сэргээх -хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх, -амьжиргааны баталгааг сэргээх,	-Хөрөнгө оруулалтын тухай хууль, -Гамшигас хамгаалах тухай хууль		
2.	Бүтээн байгуулалт	-орон сууц, -барилга байгууламж, -дэд бүтцийг сэргээн засварлах, шинаэр төлөвлөх, дахин барих үйл ажиллагаа	-Барилгын тухай хууль, -Гамшигас хамгаалах тухай хууль, -Холбогдох стандарт, норм ба дурмууд	Нутаг дэвсгэрийн харьяа татварын алба, Онцгой комисс, Онцгой байдлын байгууллагад байх	
3.	Санхүүгийн дэмжтэг, хандив	-бэлэн мөнгө, -байнгын болон түр сууц, гэр, майхан, -техник, багаж хэрэгсэл, -тавилга, эд хогшил, -дугаан хувцас, ус, хоол хүнс, -эм, эмнэлгийн анхны тусгамжийн хэрэгсэл, -шатахуун, -өвс, тэжээл, -бусад	Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтолцоогийн “Гамшигаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусгамжийг зохицуулж журам” MNS стандартууд		